



# Japan International Cooperation Agency

ЖАЙКА нь Япон Улсын Засгийн Газрын Хөгжлийн Албан ёсны Тусламжийг (ODA) нэгтгэн, хөгжих буй орнуудад чиглэсэн хамтын ажиллагааг хэрэгжүүлдэг байгууллага юм. Монгол улсад 1980-аад оноос ажиллаж эхэлсэн ба олон салбарт техникийн хамтын ажиллагаа, буцалтгүй тусламж зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

Энэ төсөл нь АШУУС-ийн харъяа Монгол-Япон сургалтын эмнэлгийн үйл ажиллагааны хяналт, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх бүтцийг бий болгох төсөлтэй хамтран ажиллаж байна. Сургалтын эмнэлэгийн хувьд үр өгөөжтэй боловсрол олгох чиглэлд хамтран ажиллаж байна.



Монгол Улсын эрүүл мэндийн салбар дахь бусад ЖАЙКА-гийн төсөл Энэ төсөлтэй шууд хамааралгүй боловч Эрүүл мэндийн салбар олон төсөл хэрэгжиж байна. Түүнчлэн Японы сайн дүрийн гишүүд болох сувилагч, эх баригч, хөдөлгөөн засалч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, хоол тэжээл судлаач нар Монгол улс орон даяар ажиллаж байна.

Монгол хүүхдийн шүдний цоорлоос урьдчилан сэргийлэх төсөл

Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл



Өвсний үндэс техникийн хамтын ажиллагаа  
2017 он 10 сар - 2019 он 12 сар



Өвсний үндэс техникийн хамтын ажиллагаа  
2016 он 9 сар - 2019 он 8 сар

Монгол Улс орон даяар эрүүл мэндийн салбарын ажиллаж буй сайн дүрийн гишүүдийн үйл ажиллагаа



Монгол Улсын анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төслийн төв оффис  
ЭМХТ-ийн 3-р давхар 306 тоот, Сүхбаатар дүүрэг,  
1-р хороо, Энхтайвны гудамж 138  
Улаанбаатар 210648, Монгол Улс  
Утас: 70110894

Монгол Улсын анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний дараах сургалтыг сайжруулах төслийн салбар оффис  
Орхон аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сургалтын алба, Хангайн гудамж, Зэст, Баян-Өндөр сум, Орхон аймаг, Монгол Улс

## Монгол Улсын анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл (2015-2020)



### ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэ төсөл нь Монгол Улсын хүснэгтийн дагуу 2015 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн. Орон нутаг дахь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах үндсэн зорилготой бөгөөд ЭМЯ болон ЭМХТ-тэй хамтран хүний их эмчийн төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Тухайлбал, Монгол Улсын орон нутагт ажиллах чадвар бүхий эмчийг бэлтгэхийн тулд төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр боловсруулахад дэмжлэг үзүүлэн ажиллахыг зорьж байна. Энэ үйл ажиллагаа нь 3 том чиглэлээр хэрэгжиж байна.



ЭМЯ



ЭМХТ



① Сургалт зохион байгуулах, хянах чадавхийг сайжруулах

② Сургалтын хөтөлбөр боловсруулах, Сургач багш нарыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх

③ Орон нутагт сургалтыг хэрэгжүүлэхдэд дэмжлэг үзүүлэх

### ① Сургалт зохион байгуулах, хянах чадавхийг сайжруулах


2016 онд Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хууль батлагдсантай холбоотой Эрүүл мэндийн сайдын А/337 дугаар тушаалын 1-р хавсралтад зааснаар АУ-ны боловсрол олгох их сургуулийг төгссөн хүний их эмч нь 44 долоо хоногийн Ерөнхий мэргэшил судлалын сургалтад заавал суралцах болсон (доорхи хүснэгт). Үүнтэй зэрэгцээд одоог хүртэл сургалт эрхэлж байгаагүй олон эмнэлгүүдэд суралцагч эмчийг сургах хэрэгцээ гарч ирсэн. Төслийн хүрээнд Япон Улсын төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог танилцуулж, Монгол Улсад төгсөлтийн дараах сургалтыг үр дүнтэй сайжруулахын тулд ЭМЯ болон ЭМХТ-тэй хамтран төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлага, сургалт эрхлэгч байгууллагын үйл ажиллагаанд явцын үнэлгээ хийх шалгуур, суралцагч эмчийн үнэлгээний аргачлалыг сайжруулах үйл ажиллагааг явуулж байна.

Ерөнхий мэргэшил судлалын 44 долоо хоногийн үндсэн мэргэшлийн сургалт (дотор, хүхэр, эх барих эмэгтэйчүүд, яаралтай тусламж*мэс заслын тойролт)*орон нутгийг оролцуулан 2 дахь шатлалын эмнэлгүүдэд явагдана.	Ерөнхий мэргэшлийн эмчээр орон нутагт, Улаанбаатар хотын анхан шатлалын эмнэлэгт 3 жил ажиллана.	Үндсэн мэргэшлийн сургалт (2~3 жил) 3 дахь шатлалын эмнэлэгт явагдана.	Төрөлжсөн мэргэшлийн сургалт (1 жил ~)
Үндсэн мэргэшлийн сургалт (3~4 жил) 44 долоо хоногийн ерөнхий мэргэшил судлалын сургалтыг оруулаад	Орон нутагт үргэлжлүүлэн ажиллана.	Монгол Улсын төгсөлтийн дараах эмнэл зүйн сургалтын тогтолцоо	

## ② Сургалтын хөтөлбөр боловсруулах, Сургагч багш нарыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх

Сайн эмчийг бэлтгэхийн тулд сайн сургалтыг олгох хэрэгтэй. Сайн сургалтыг олон тулд сайн хөтөлбөр хэрэгтэй. Манай төсөл нь сургагч багшийн сургалтыг (TOT) боловсруулах, дэлхийн стандартад нийцсэн "сургалтын хөтөлбөрийг боловсруулах, тасралтгүй сургалтын багцыг боловсруулах зэрэгт дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Эмчийг бэлтгэх үйл явцыг хоол хийхтэй адилтгавал



## Сургагч багшийг бэлтгэх



ТОТ сургалт

Япон Улсын "Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам"-ны удирдамжийн дагуу зохион байгуулагддаг сургагч багшийн сургалтын агуулгыг үндэслэн Монгол Улсын сургагч багшийг бэлтгэх ТOT сургалтыг боловсруулсан. Уг сургалтыг заах, зохион байгууллага монгол чиглүүлэгч багш нарыг мөн бэлтгэж байна. Сургалт эрхлэх байгууллага болгонд TOT сургалтад хамрагдсан эмч нар байх шаардлагатай бөгөөд цаашид энхүү сургалтыг Монгол Улс орон даяар түгээн дэлгэрүүлэхэд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлж ажиллана.

Дэлхийн стандартад нийцсэн хөтөлбөр боловсруулах

Хөтөлбөр боловсруулах семинар



Ерөнхий мэргэшлийн эмчийг бэлтгэхэд шаардлагатай хөтөлбөрийг боловсруулахад дэмжлаг үзүүлж байна. Дэлхийн чиг хандлагыг даган чадамжид сууриссан хөтөлбөрийг боловсруулж байна.

Монгол Улсын орон нутагт ажиллах чадвар бүхий ерөнхий мэргэшлийн эмчийн эзэмших шаардлагатай чадамжийг (competency) олгох хөтөлбөрийг боловсруулж байна.

Монгол Улсын ерөнхий мэргэшлийн эмчийн цөм чадамж



## Тасралтгүй сургалтын багцыг боловсруулах нь



Эмч мэргэжилтний тасралтгүй сургалтын багцыг боловсруулж байна. Япон мэргэжилтний зааврын дагуу яаралтай тусlamжийн сургалтын багцыг боловсруулсан бөгөөд одоогоор монгол эмч нар сургалтыг заан явуулж байна.



Цаашид хүүхдийн өвчин судлал, халдварт өвчин судлалын чиглэлээр сургалтын багцыг боловсруулахаар төлөвлөж байна.

## ③ Орон нутагт сургалтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Орон нутагт сургалтыг хэрэгжүүлэхэд дэмжин ажиллаж байна. Орхон болон бусад аймгийг загвар аймаг болгон аймгийн эрүүл мэндийн газар, аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллаж байна. Өнөөг хүртэл загвар аймгуудад олон удаагийн тасралтгүй сургалт, Орхон аймагт TOT сургалтыг зохион байгуулсан. Түүнчлэн телемедицин систем ашиглан зайн сургалт, хурлыг зохион байгуулсан.



ТОТ сургалт



PBLS сургалт



Зайн сургалт, хурал



Энэ төсөл нь аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хэрэгжүүлэх ерөнхий мэргэшил судлалын сургалтыг бодитоор дэмжин ажиллаж байна. Сургалт хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын хяналтын тогтолцоог бий болгох, сургалтын хөтөлбөрийг боловсруулах зэрэгт арга зүйн зөвлөгөө үзүүлж байна.



Цаашид орон нутагт төгсөлтийн дараах эмнэлэгүүн сургалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, түүнчлэн боловсронгуй сургалтын тогтолцоог Монгол улс орон даяар дэлгэрүүлэх зэрэгт дэмжлэг үзүүлэн ажиллахаар төлөвлөж байна.



ДОРНОД БОЭТ